

**Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна**

**Абрахамд
өгсөн
Бурхны
амлалт**



Зохиогч: Edward Hughes
Зураглаач: Byron Unger; Lazarus
Найруулсан: M. Maillot; Tammy S.
Орчуулсан: Damdin Horolsuren
Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

BFC
PO Box 3
Winnipeg, MB R3C 2G1
Canada

©2014 Bible for Children, Inc.
Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.



**Үер болсноос хойш
олон жилийн дараа
дэлхийн хүмүүс
нэгэн төлөвлөгөө
гаргажээ.**



Тэд "Бүгдээрээ хот болон тэнгэр
тулам оройтой өндөр цамхаг
барьж байгуулцгаая" "Тэгээд
үргэлж хамтдаа амьдарцгаая"
гэв. Бүх хүн нэг хэлээр
ярьдаг байв.



**Бурхан хүмүүсийг өөрийнх нь бүтээсэн
дэлхий ертөнцөд тарж амьдраасай гэж
хүсэв. Тиймээс тэр онцгой зүйлийг
тэдэнд бэлджээ. Гэнэт нэг хэсэг
хүмүүс өөр хэлээр ярьж эхлэв.
Бурхан тэдэнд шинэ хэл
өгчээ.**



**Адил хэлээр ярьдаг хүмүүс хамтдаа тэндээс нүүв.
Магадгүй хүмүүс бусдын яриаг ойлгохгүй болохоор
бусдаас айдаг байх.**




Ийм замаар Бурхан олон орны хүмүүсийг бий болгожээ. Тэдний орхисон хотын нэр бол Бабел гэдэг ба самуурсан гэсэн утгатай ажээ.



**Энэ явдлаас олон
жилийн дараа
Бурхан Халдеин
Урт Бурхан Абрам
гэдэг хүнтэй ярив.
Бурхан "Энэ газрыг
орхи" гэж айлдаад
"Миний чамд
үзүүлэх газар
уруу яв" гэв.**




Абрам дуулгавартай дагав. Бурхан түүнийг Канаан нутаг уруу дагуулав. Түүнтэй хамт түүний эхнэр Сарай болон ач дүү Лот нь хамт явав.



**Канаан нутагт очоод Абрам болон
Лот маш их эд хөрөнгөтэй болов. Тэд
маш олон мал сүрэгтэй байв. Тэнд
тэдэнд мал сүрэгээ бэлчээрлүүлэх
газар хүрэлцэхгүй байв.**



Тэгээд Абрамын малчид Лотын малчид
хоорондоо маргалджээ. Тэгэхэд Абрам
"Бидний дунд маргаан бүү гараг" гээд
"Бид салж нүүе чи эхлээд хаашаа
нүүхээ сонго" гэв.



Лот олон хот тосгонтой, дүүрэн өвстэй тал уудам тал газрыг сонгов. Энэ газар сайхан харагджээ. Гэвч энэ газрын хотууд нь бузар муугаар дүүрсэн байв.



**Лотыг нүүсний дараа Бурхан
Абрамтай дахин ярив. "Би
Канаан нутгийг чамд болон чиний
үр хүүхдэд үүрд өгнө" гэв. Абрам
Сараи хоёр үр хүүхэдгүй байв.
Бурхны**

**ЭНЭ АГУУ
АМЛАЛТ
ХЭРХЭН
БИЕЛСЭН
БОЛ?**





**Бурхны гурван элч Абрам Сарай хоёр дээр ирэв.
"Та хоёр удахгүй хүүхэдтэй болно" гэж тэдэнд
хэлэв. Сарай инээв. Тэр Бурхны хэлсэнд
итгэсэнгүй. Тэр ерэн настай байжээ.**





**Бурхан Абрамд одооноос эхлээд чамайг
Абрахам {"олон үндэстний өвөг"} гэх болно
гээд Сарайг Сара {"гүнж"} гэх болно гэв.**



**Бурхан Абрахамд
Содом Гоморра гэдэг
хоёр хот гэм нүгэл нь
дэндүү их учир устгах
болно гэж хэлэв. Содом
хотод Абрахамыг ач
дүү Лот амьдарч байв.**



**Лот Бурхныг
анхааруулахад
итгэсэн боловч
түүний охид болон
тэдний нөхрүүд нь
Содом хотыг орхиж
явахаас татгалзав.
Ямар харамсалтай
вэ! Тэд Бурхны
үгэнд итгэсэнгүй.**



Зөвхөн Лот болон түүний
хоёр охин нь аврагдав. Ёс
бус хот дээр хүхэр болон
гал тэнгэрээс
цутгав.



Лотын эхнэр Бурханд
дуулгавартай байж чадалгүй
зугтан гүйж байхдаа эргэж
харав. Тэгтэл тэр
давсан багана
болов.



**Эзэн Абрахам
Сара хоёрт
өгсөн
амлалтаа
хадгалсаар
байв. Тэд
Бурхны
хэлснээр өгөл
насандаа
хүүтэй болов.
Исаакийг
төрөх үед
тэд ямар их
баярласан бол!**



**Магадгүй
Абрахам тэр үед
Бурхны Канаан
нутгийг өөрийнх нь
үр удамд үүрд өгнө
гэсэн Бурхны
амлалтыг**



**санасан
байх.**

**Бурхан тэр
амлалтандаа
ч хүрсэн юм.
Бурхан үргэлж
амласанаа
биелүүлдэг.**



Абрахамд өгсөн Бурхны амлалт

Бурханы үг Библиээс авсан түүх

Эхлэл 11-21

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130





Төгсөв



4



60



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16

